



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/151

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/87 дугаар тушаалаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагнал олгох журам" /цаашид "журам" гэх/-ын 3 дугаар зүйлд 3.5¹, 3.5² дахь хэсэг нэмсүгэй:

"3.5¹. Монгол Улсын техник технологийн хөгжилд хувь нэмэр оруулж, 10-аас доошгүй шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ авсан, түүнчлэн эдийн засагт ач холбогдол бүхий шинэ санаачлагыг практикт нэвтрүүлсэн "Шинийг санаачлагч" тэмдгээр шагнагдсан болон онцгой шинэ санаачлага гаргасан зохион бүтээгч, иргэнийг "Шилдэг зохион бүтээгч" тэмдгээр шагнана.

3.5².Шинэ санаачлага гарган 5-аас доошгүй патент, ашигтай загварын гэрчилгээ авч, практикт нэвтрүүлсэн иргэнийг "Шинийг санаачлагч" тэмдгээр шагнана."

2.Журмын 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4.10 дахь хэсэг нэмсүгэй:

"4.10."Шилдэг зохион бүтээгч", "Шинийг санаачлагч" тэмдгээр шагнуулахаар иргэнийг харьяалах байгууллагаас, ямар нэг байгууллагад харьяалагддаггүй бол баг, хорооноос нэр дэвшүүлж, оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд оюуны өмчийн байгууллага бичиг баримтын бүрдэлт, шагнуулах үндэслэл, тодорхойлолтыг хянан үзэж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжилна."

3.Журмын 2.1.1 дэх заалтад дор дурдсан агуулгатай дэд заалт нэмсүгэй.


"2.1.1.6 "Шилдэг зохион бүтээгч" тэмдэг;

2.1.1.7 "Шинийг санаачлагч" тэмдэг."

4.Журмын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийн "Хуульчдын өдрөөр" гэснийг "Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, "Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-д заасан тэмдэглэлт өдрөөр" гэж өөрчилсүгэй.

08 0654

5.Журмын 5 дугаар зүйлийн 5.4, 5.6 дахь хэсэг, шагналын /анкет/ тодорхойлолтын "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" гэсний дараа "Шилдэг зохион бүтээгч", "Шинийг санаачлагч" гэж тус тус нэмсүгэй.



С.БЯМБАЦОГТ